



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/16

Эрдэнэт

Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, дүгнэх, урамшуулал олгох журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам” батлах тухай Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, дүгнэх, урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Журмыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналт шалгалтын комиссын дарга (О.Заяа)-д үүрэг болгосугай.
- Мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүр байгууллагын төсөөвт суулгуулж ажиллахыг нягтлан бодогч (Ж.Нямжаргал)-д үүрэг болгосугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан даргын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Биеийн тамир, спортын газрын ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА   
Д.ДЭЛГЭРБАЯР

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн шалгуур, үзүүлэлтийн нөхцөл хангасан ажилчдад мөнгөн урамшуулалт олгоно.

1.2. Төрийн үйлчилгээний албан хаагчдын улирлын мөнгөн урамшууллын дээд хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй бөгөөд урамшууллын мөнгийг цалингийн санд багтаан улирал бур олгоно.

## Хоёр, Дүгнэх үзүүлэлт:

2.1. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн ажилтныг хариуцан ажиллаж байгаа нэгжийн дарга шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, байгууллагын дарга хянаж, баталгаажуулна.

2.2. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг тооцоходоо 4 шалгуур, үзүүлэлт тус бүрт нь 0-25 оноо өгч нийт 4 үзүүлэлтийн дундажаар 0-100 оноогоор үнэлнэ. Дараах үнэлгээгээр үнэлэгдэнэ:

91-100 оноо буюу хувь авсан бол

## “бүрэн хангалттай”

71-90 онро буюу хувь авсан бол

"хангалттай"

70-өөс доош оногийн хувь авсан бол

## "хангалтгүй"

-Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн оноо, буюу хувь:

Ур чадварын үнэлгээний улирлын шалгуур, үзүүлэлт	Үйлчилгээний стандарт. Ёс зүйн дүрмийн шалгуур, үзүүлэлт	Ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур, үзүүлэлт	Даргын шууд үнэлгээний шалгуур, үзүүлэлт	Нийт ажил үйлчилгээний шалгуур, үзүүлэлт
0-25	0-25	0-25	0-25	
	96-100% нь 25 оноо			
	91-95% нь 20 оноо			
	86-90% нь 15 оноо			
	81-85% нь 10 оноо			
	76-80% нь 5 оноо			
	71-75% нь 3 оноо			
	66-70% нь 1 оноо			
	65%-оос доош 0 оноо			

-Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэх хүснэгт:

№	Албан тушаал	Овог, нэр	Үр чадварын үнэлгээний улсырлын шалгувур, үзүүлэлт	Үйлчилгээний стандарт, Ёс зүйн дурмийн шалгувур:	Узүүлэлт Т Ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгувур, үзүүлэлт	Даргин шүүд үнэлгээний шалгувур, үзүүлэлт	Нийт ажил, үйлчилгээний шалгуур, үзүүлэлт
						ОНОО, ХУВЬ	ҮНЭЛГЭЭ ХАГИАНД НӨГДОХ ХУВЬ

Хэрэв "бүрэн хангалттай", эсхүл "хангалтгүй" гэсэн үнэлгээ өгсөн бол цаашид хэрэгжүүлэх ажлын санал бичнэ:

2.3. Ажилчдад ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр мөнгөн урамшуулал болон хариуцлагын арга хэмжээ тооцно.

Үр дүнгийн урамшууллын үнэлгээ		Албан тушаалын үндсэн цалингаас урамшуулал тооцох хувь
үнэлгээ	хувь	
бүрэн хангалттай	91-100	31%-40%
хангалттай	81-90	21%-30%
	71-80	11%-20%
хангалтгүй	70-аас доош	хугацаатай үүрэг, даалгавар өгөх, сургалтад хамруулах, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн зөвлөлийн журмын дагуу хариуцлага тооцох

2.4. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биөлэлт 70-оос доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчид улирлын урамшуулал олгохгүй бөгөөд ажлын үр дүнг дээшлүүлэх хугацаат үүрэг, даалгавар өгөх, З удаа "хангалтгүй" үнэлгээнээр үнэлэгдсэн бол холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шат дараалсан арга хэмжээ тооцно.

2.5. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн ажилтанд улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.

2.6. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэх хүснэгтийг үндэслэн хүний нөөцийн ажилтан ногдох урамшууллын хувийг нэгтгэж, даргын тушаалаар баталгаажуулна.

----оОо----